

Агуулга

Судалгааны зорилго

Судалгааны агуулга

НЭГ. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

ХОЁР. ОНОЛЫН ХЭСЭГ

ГУРАВ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

3.1. Малтай өрх, малчдын тоо тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

3.1.1 Малтай өрх, малчдын тоо

3.1.2 Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

3.2. Мал тэжээвэр амьтдын тоо, бүтэц

3.2.1 Малын тоо, бүтэц

3.2.2 Хувийн малын тоо

3.2.3 Малын бүлэглэлт

3.2.4 Хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироо

3.2.5 Төл бойжилт

3.2.6 Том малын зүй бус хорогдол

3.2.7 Малын хэрэглээний зарлага, сүргийн бүтэц

3.3. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

3.3.1 Бэлчээрийн хүрэлцээ, хангамж

3.3.2 Шинээр гаргасан худгийн тайлан

3.3.3 Засварласан худгийн тайлан

3.4. Газар тариалангийн үйлдвэрлэл

3.5. Улс, бүсэд эзлэх байр суурь

ДҮГНЭЛТ

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

“Баянхонгор аймгийн хөдөө аж ахуй” сэдэвт энэхүү судалгааны зорилго нь мал аж ахуйн салбарын ирээдүйн хөгжил, малчдын амьжиргааны талаар бодлого, малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, малын төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, сувайралт, хээл хаялт, бэлчээрийн даац хүрэлцээ, тэжээвэр амьтад, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд болон хөдөө аж ахуйн салбарын цаашдын чиг хандлагыг тодорхойлохын зэрэгцээ манай улсын мал аж ахуйн үйлдвэрлэлд аймгийн эзлэх байр суурийг харуулсан мэдээллээр аймгийн удирдлагууд болон хэрэглэгчдийг хангах зорилготой юм.

СУДАЛГААНЫ АГУУЛГА

Манай улсын эдийн засгийн гол үндэс болсон бэлчээрийн мал аж ахуйн салбар нь эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлогод гол байр суурь эзэлсэн хэвээр байна.

Мал аж ахуйн салбар нь хүн амыг мах сүү, цагаан идээ зэрэг хүнсний бүтээгдэхүүнээр, боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах үндсэн эх булаг болохын зэрэгцээ манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр - 1 бод

1 тэмээ - 1.5 бод

6 хонь - 1 бод

8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь

1 адуу - 7 хонь

1 үхэр - 6 хонь

1 хонь - 1 хонь

1 ямаа - 0.9 хонь

Хонин толгойд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - Тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай

Адуу- Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25

Азарга - 12-15

Бух - 35-45

Хуц, ухна - 25-30

Том малын зүй бус хорогдолд Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс - 0.45

Таримал тэжээл - 0.35

Даршны ургамал - 0.25

Гар тэжээл, хужир шүү - 1.00

Төмс ногооны хаягдал - 0.22

Үр тарианы хаягдал - 0.90

Лай - 0.40

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.

2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.

3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.

- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм. Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2016 оны төлөв байдлыг нэгтгэн тусгав.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллогыг 2018 оны 12 дугаар сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж явуулав.

Энэхүү танилцуулгад 2018 оны мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал эмнэлгийн арга хэмжээ, шинээр гаргасан, сэргээн засварласан худаг, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган

оруулав.Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

III.1 МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1.1 Өрх, малчдын тоо, насны бүтэц

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээс харахад нийт 14765 малтай өрх тоологдсоны дотор 11920 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж үүнд 21784 малчид ажиллаж байна.

Аймгийн хэмжээний нийт өрхийн 55.4 хувийг хувийн малтай өрх эзэлж байна.

Малчдын тоог насны бүлгээр нь авч үзвэл 40.7 хувь нь 16-34 насны, 52.5 хувь нь 35-59 насны, 6.8 хувь нь тэтгэврийн насны хүмүүс болно.

Мал бүхий өрх, малчин өрхийн тоог сумдаар харуулбал:

хүснэгт 1

Сум/дүүрэг	Малтай өрхийн тоо	Үүнээс					
		Малчдын тоо	Үүнээс: эмэгтэй	16-34	35-59	60+	
Баянхонгор сум	828	488	799	329	278	461	60
Баацагаан сум	917	746	1 328	576	582	675	71
Баянбулаг сум	390	253	510	227	197	297	16
Баянговь сум	695	595	1 078	507	464	552	62
Баянлиг сум	858	696	1 358	615	622	669	67
Баян-Овоо сум	691	514	797	329	256	460	81
Баян-Өндөр сум	610	480	963	425	427	507	29
Баянцагаан сум	889	667	1 200	533	461	655	84
Богд сум	733	669	1 195	546	457	629	109
Бөмбөгөр сум	847	733	1 311	584	631	598	82
Бууцагаан сум	918	758	1 359	615	498	751	110
Галуут сум	966	830	1 546	703	654	811	81
Гурванбулаг сум	530	397	739	322	298	388	53
Жаргалант сум	744	591	1 037	471	347	598	92
Жинст сум	536	484	930	424	426	444	60
Заг сум	530	419	769	347	260	437	72
Өлзийт сум	941	878	1 668	780	653	866	149
Хүрээмарал сум	455	327	620	283	242	329	49
Шинэжинст сум	639	477	868	387	382	442	44
Эрдэнэцогт сум	1 048	918	1 709	813	725	861	123
	14 765	11 920	21 784	9816	8 860	11430	1494

2018 онд малтай өрх өмнөх оноос 199 -өөр, малчин өрхийн тоо 99 -өөр тус тус өссөн.

хүснэгт 2

	Хэмжих	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
	нэгж						Хувь	Зөрүү
Малтай өрх	тоо	13424	13644	14162	14566	14765	100	199
Үүнээс: малчин өрх	тоо	10614	10607	11171	11821	11920	101	99
Малчдын тоо	тоо	20962	21062	21990	22255	21784	97.9	-471
Үүнээс: 16-34 насны	хүн	9239	9084	9314	9230	8860	96	-370
35 ба 59 нас хүртэл	хүн	10136	10496	11071	10689	11430	107	741
Тэтгэвэрийн насны	хүн	1587	1482	1605	2250	1494	66.4	-756
Насны бүтэц%	%	100	100	100	100	100	100	0
Үүнээс: 16-34 насны	%	44.1	43.1	42.4	41.5	40.7	98.1	-0.8
35 ба 59 нас хүртэл	%	48.3	49.8	50.4	48.1	52.5	109	4.4
Тэтгэвэрийн насны	%	7.6	7	7.2	10.4	6.8	65.4	-3.6

Мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа малчдын тоо өмнөх оноос 2.1 хувь буюу 471 - ээр буурсан байна.



Насны бүтцийг 2014 онтой харьцуулж үзэхэд 35-59 насны малчдын тоо 10.8 хувиар өсч 60-с дээш буюу тэтгэвэрийн насны малчдын тоо 45.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3.1.2 Малчдын соёл ахуйн зарим үзүүлэлтүүд

Малчдын ахуй соелын үзүүлэлт нь малчдын амьжиргааг илэрхийлдэг гол үзүүлэлт билээ. Манай аймгийн хувьд 2018 оны жилийн эцсийн мал тооллогоор нийт малчин өрхийн 80.7 хувь нь цахилгааны эх үүсвэртэй, 73.2 хувь нь телевизортой, 45.9 хувь нь автомашинтай, 61.3 хувь нь мотоцикльтой, 0.2 хувь нь трактортай гэсэн дүн гарчээ.

Манай аймгийн малчдын цахилгааны болон телевизор, машин, мотоциклийн хангамжийн үзүүлэлт хангайн бүсийн дундажаас дээгүүр байна. Малчдын цахилгаан хангамжийн үзүүлэлт болон телевизор, автомашин, мотоциклын хэрэглээ 1990, 2000 оны түвшингээс эрс дээшилжээ.

хүснэгт 3

	Өрхийн тоо					Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2014	2015	2016	2017	2018	2014	2015	2016	2017	2018
Цахилгаантай	9582	9418	9709	9987	9625	90.3	88.8	86.9	84.5	80.7
Телевизортой	8602	8517	8453	8970	8726	81	80.3	75.7	75.9	73.2
Автомашинтай	4161	3864	3890	4667	5469	39.2	37.3	34.8	39.5	45.9
Мотоцикльтой	7373	7082	6380	7129	7306	69.4	66.8	57.1	60.3	61.3
Трактортой	49	40	42	47	29	0.5	0.4	0.4	0.4	0.2

III.2 МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, БҮТЭЦ

3.2.1 Малын тоо, бүтэц


2018 оны жилийн эцэст манай аймгийн мал сүргийн нийт дүн 4249.5 мянга болж, 2017 оныхоос 7.4 хувь буюу 338.3 мянган толгойгоор буурлаа. Адуун сүргийн тоо 175.9 мянга, үхэр 239.8 мянга, тэмээ 57.4 мянга, хонь 1297.5 мянга, ямаа 2478.9 мянган толгойд хүрч, 2017 оныхоос адуу -4184, үхэр -565, хонь -83658, ямаа -252897 толгойгоор тус тус буурч, тэмээн сүрэг 3039 толгойгоор өссөн байна.

Нийт малын тооны өсөлт / 2014-2018 он, тоо /

Хүснэгт 4

Малын төрөл	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
						Хувь	Зөрүү
Тэмээ	41668	44496	49660	54349	57388	106	3039
Адуу	126311	141338	159143	180128	175944	97.7	-4184
Үхэр	170767	189019	213809	240342	239777	99.8	-565
Хонь	989016	1082565	1244588	1381125	1297467	93.9	-83658
Ямаа	2138102	2314449	2569121	2731794	2478897	90.7	-252897
Нийт малын тоо	3465864	3771867	4236321	4587738	4249473	92.6	-338265

Нийт малын тооны өсөлт /2014-2018 он, тоо/




Нийт мал сүргийн дотор адуу 4.1 хувь, үхэр 5.6 хувь, тэмээ 1.4 хувь, хонь 30.6 хувь, ямаа 58.3 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос ямааны эзлэх хувь 1.2 пунктээр буурч, хониных 0.5 пункт, адууных 0.2 пункт, үхэр 0.4 пункт, тэмээнийх 0.2 пунктээр өссөн байна.

1970 онд бог мал нийт сүргийн 79.9 хувийг эзэлж байсан ба үүний дотор хонь 50.6 хувь, ямаа 29.3 хувийг эзэлж байсан бол 2018 онд бог мал 88.8 хувийг эзэлж, хонь 30.5 хувь ямаа 58.3 хувийг эзэлж байгаа нь ямаан сүргийн эзлэх хувийн жин 29 пунктээр нэмэгдэж, хонин сүргийн эзлэх хувийн жин 20.1 пунктээр буурсан нь сүүлийн жилүүдэд ноолуурын үнэ өсч байгаатай холбоотой малчид ямааг ихээр өсгөх болсон байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

Хүснэгт 5

	2014	2015	2016	2017	2018
Бүгд	100	100	100	100	100
Тэмээ	1.2	1.2	1.2	1.2	1.4
Адуу	3.6	3.7	3.8	3.9	4.1
Үхэр	4.9	5	5	5.2	5.6
Хонь	28.5	28.7	29.4	30.1	30.5
Ямаа	61.7	61.4	60.6	59.5	58.3



Хамгийн олон мал тоолуулсан эхний 5 сумд Баацагаан (322229), Галуут (289552), Бууцагаан (279027), Бөмбөгөр (270868), Баянцагаан (247016) сумууд орж байна. Малын төрлөөр нь авч үзвэл тэмээгээр Баянлиг 23064, адуугаар Галуут 19857, үхрээр Эрдэнэцогт 51745, хониор Галуут 126616, ямаагаар Баацагаан 241995 толгойг тус тус тоолуулж аймагтаа тэргүүлж байна.

	1-рт	2-рт	3-рт	4-рт	5-рт
Нийт малын тоогоор	Баацагаан-358716	Галуут-289552	Бууцагаан-279027	Бөмбөгөр-270868	Баянцагаан-19857
Тэмээ	Баянлиг-23064	Шинэжинст-6133	Богд-5974	БаянӨндөр-4973	Баянговь-4646
Адуу	Галуут-19857	Жаргалант-13396	Гурванбулаг -13146	Өлзийт-12950	Эрдэнэцогт-12575
Үхэр	Эрдэнэцогт-51745	Галуут-34920	Жаргалант-30217	Баянхонгор-23321	Гурванбулаг -18698
Хонь	Галуут-126616	Баян-Овоо-113372	Гурванбулаг-95786	Хүрээмарал-86607	Өлзийт-83072
Ямаа	Баацагаан-241995	Бууцагаан-188011	Бөмбөгөр-177708	Баянцагаан-177408	Баянговь-166288

Аймгийн хэмжээнд нийт малын тоогоор Баацагаан сум, тэмээгээр Баянлиг сум, адуугаар Галуут сум, үхрээр Эрдэнэцогт сум, хониор Галуут, ямаагаар Баацагаан сум тус тус тэргүүлж байна.

Малын тоо, / сумаар /

Нийт малын тооны зэрэгцүүлэлт / сумаар /

хүснэгт 7

Сум						2018/2017	
	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018	%	зөрүү
Баянхонгор	165 750	149286	169373	171723	162 605	94.7	- 9 118
Баацагаан	278 557	313931	357184	358716	322 229	89.8	- 36 487
Баянбулаг	91 922	100240	116501	134229	137 929	103	3 700
Баянговь	159 653	181774	206971	233189	206 300	88.5	- 26 889
Баянлиг	189 783	207677	223050	245407	219 625	89.5	- 25 782
Баян-Овоо	215 911	224868	250576	246598	228 676	92.7	- 17 922
Баян-Өндөр	133 621	154744	187044	212083	171 825	81	- 40 258
Баянцагаан	182 264	214591	261749	286855	247 016	86.1	- 39 839
Богд	205 834	213316	234347	231747	209 989	90.6	- 21 758
Бөмбөгөр	198 079	220589	255757	277585	270 868	97.6	- 6 717
Бууцагаан	239 682	263415	290991	309306	279 027	90.2	- 30 279
Галуут	207 935	224416	249715	284831	289 552	102	4 721
Гурванбулаг	104 498	120855	138641	163649	184 865	113	21 216
Жаргалант	115 175	127508	142369	166910	167 784	101	874
Жинст	167 367	188481	207474	220233	182 825	83	- 37 408
Заг	117 275	126606	143769	164002	160 217	97.7	- 3 785
Өлзийт	253 221	265 224	251001	265104	236 368	89.2	- 28 736
Хүрээмарал	162 831	171507	191596	219472	203 212	92.6	- 16 260
Шинэжинст	126 570	150351	187412	203675	180 737	88.7	- 22 938
Эрдэнэцогт	149 936	152488	167801	192121	187 824	97.8	- 4 297
Дүн	3465864	3771867	4236321	4587738	4249473	92.6	- 338 265

3.2.3 Малтай өрхийн малын бүлэглэлт

хүснэгт 8

	Малтай өрх		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	2017	2018	2017	2018	2017	2018
ДҮН	186	223	1.3	1.5	1 242	1 579
10 хүртэл малтай	685	767	4.7	5.2	14 906	16 608
11-30	782	901	5.4	6.1	32 639	37 445
31-50	1 707	1 810	11.7	12.3	128 483	135 480
51-100	3 093	3 250	21.2	22.0	460 504	484 290
101-200	5 316	5 447	36.5	36.9	1 711 889	1 752 675
201-500	2 109	1 948	14.5	13.2	1 397 932	1 305 300
501-999	609	370	4.2	2.5	683 694	417 986
1000-1499	55	35	0.4	0.2	91 807	59 011
1500-2000	24	14	0.2	0.1	57 549	34 027
2001-ээс дээш	14 566	14 765	100	100.0	4580645	4 244 401

Иргэдийн хувийн малын тоог бүлэглэж судалбал 2017 оныхоос 11-30 малтай өрхийн тоо 0.7 хувиар, 51-100 малтай өрхийн тоо 0.8 хувиар, 101-200 хүртэл малтай өрхийн тоо 0.4 хувиар тус тус өсч, 201-500 малтай өрхийн тоо 1.3 хувиар, 501-999 малтай өрхийн тоо 2.3 хувиар, 1000-1499 малтай өрхийн тоо 0.2 хувиар, 2000 дээш малтай өрхийн тоо 0.1 хувиар тус тус буурсан байна.

Малтай өрхийн малын бүлэглэлт /сумаар/

хүснэгт 9

МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ /сумаар/

	Бүгд	10 хүртэл	11-30	31--50	51--100	101-200	201-500	501-999	1000-1499	1500-2000	2001-дээш
Баянхонгор	828	14	54	74	146	247	242	46	4		1
Баацагаан	917	9	37	35	77	160	376	191	29	3	
Баянбулаг	390	6	11	16	62	71	123	80	20	1	
Баянговь	695	8	33	41	91	115	292	101	14		
Баянлиг	858	16	44	50	109	191	360	76	10	1	1
Баян-Овоо	691	4	28	47	74	127	271	106	30	4	
Баян-Өндөр	610	2	32	36	66	125	255	85	9		
Баянцагаан	889	11	46	57	93	190	378	99	11	3	1
Богд	733	13	41	39	74	158	282	117	8	1	
Бөмбөгөр	847	5	28	42	65	137	427	128	13	1	1
Бууцагаан	918	11	36	37	112	196	357	146	23		
Галуут	966	27	41	52	108	222	344	137	33	1	1
Гурванбулаг	530	9	26	29	60	142	151	63	41	6	3
Жаргалант	744	34	64	64	115	185	199	66	17		
Жинст	536		25	26	43	100	229	95	15	2	1
Заг	530	8	34	43	51	118	171	79	25	1	
Өлзийт	941	16	72	66	134	219	318	101	12	1	2
Хүрээмарал	455	4	15	8	36	76	164	103	40	7	2
Шинэжинст	639	2	38	53	73	119	251	90	11	1	1
Эрдэнэцогт	1048	24	62	86	221	352	257	39	5	2	
Дүн	14765	223	767	901	1810	3250	5447	1948	370	35	14

МАЛЧИН ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

Хүснэгт 10

	Малчин өрхийн тоо				Дүнд эзлэх хувь				Малын тоо			
	2014	2015	2016	2018	2014	2015	2016	2018	2014	2015	2016	2018
10 хүртэлх	103	82	88	102	1.0	0.8	0.8	0.9	688	562	608	744
11--30	380	332	356	410	3.6	3.1	3.2	3.4	8296	7416	7 883	9 023
31-50	449	411	460	513	4.2	3.9	4.1	4.3	18528	16912	19 091	21 361
51-100	1223	1121	1 150	1 162	11.5	10.6	10.3	9.7	92612	85026	86 827	88 473
101-200	2564	2413	2 304	2 540	24.2	22.7	20.6	21.3	384039	362172	348 734	382 023
201-500	4233	4311	4 462	4 887	39.9	40.6	39.9	41.0	1339287	1378526	1 452 190	1 591 374
501-999	1327	1499	1 745	1 891	12.5	14.1	15.6	15.9	865861	987152	1 155 319	1 269 054
1000-1499	293	392	535	368	2.8	3.7	4.8	3.1	329811	441901	598 642	415 256
1500-2000	30	30	52	35	0.3	0.3	0.5	0.3	49606	51006	86 486	57 306
2001 дээш	12	16	19	12	0.1	0.2	0.2	0.1	27989	38735	45 525	32 019
Дүн	10614	10607	11171	11920	100.0	100.0	100.0	100.0	3116717	3369408	3801305	3866633

МАЛЧИН ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ /сумаар/

Хүснэгт 11

	Бүгд	10 хүртэл	11--30	31--50	51--100	101-200	201-500	501-999	1000-1499	1500-2000	2001-дээш
Баянхонгор	488	3	16	35	71	148	169	41	4	1	
Баацагаан	746	2	20	17	47	117	332	180	28	3	
Баянбулаг	253		2	4	15	40	96	75	20	1	
Баянговь	595	6	21	22	56	98	281	97	14		
Баянлиг	696	3	25	25	65	154	337	75	10	1	1
Баян-Овоо	514	2	21	21	42	97	199	98	30	4	
Баян-өндөр	480	1	11	14	28	89	244	84	9		
Баянцагаан	667	1	12	26	45	128	344	97	10	3	1
Богд	669	7	30	29	57	143	277	117	8	1	
Бөмбөгөр	733		16	26	52	109	387	128	13	1	1
Бууцагаан	758	4	20	18	63	148	339	143	23		
Галуут	830	20	25	35	82	187	311	135	33	1	1
Гурванбулаг	397	2	7	14	33	106	126	60	41	5	3
Жаргалант	591	17	38	42	82	152	178	65	17		
Жинст	484		16	19	28	90	219	94	15	2	1
Заг	419	3	18	24	40	85	145	78	25	1	
Өлзийт	878	10	54	52	117	216	314	100	12	1	2
Хүрээмарал	327		1	5	16	44	118	95	40	7	1
Шинэжинст	477	2	12	23	36	74	227	90	11	1	1
Эрдэнэцогт	918	19	45	62	187	315	244	39	5	2	
Дүн	11920	102	410	513	1162	2540	4887	1891	368	35	12

3.2.4 Хээлтэгч малын тоо

Хээлтэгч малын тоо /тол/

хүснэгт 12

						2018/2017	
						%	зөрүү
Ингэ	14020	15197	16963	18587	19666	105.8	1079
Гүү	36395	41327	48420	53853	57480	106.7	3627
Үнээ	62932	69425	79288	88143	93205	105.7	5062
Эм хонь	417742	457998	529997	576082	613345	106.5	37263
Эм ямаа	879340	946183	1066059	1088832	1171405	107.6	82573
Дүн	1410429	1530130	1740727	1825497	1955101	107.1	129604

2018 оны эцэст 1955101 толгой хээлтэгч мал тоологдсон нь 2017 оныхоос 129604 толгойгоор буюу 7.1 хувиар өссөн байна. Төрлөөр авч үзвэл хээлтэгч малын тоо бүх төрөл дээр өссөн бөгөөд ингэ 1079, гүү 3627, үнээ 5062, эм хонь 37263, эм ямаа 82573 толгойгоор тус тус өссөн байна.

Хээлтэгч мал нийт малын 46 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 34.2 хувь, адуун сүргийн 32.7 хувь, үхэр сүргийн 38.9 хувь, хонин сүргийн 47.3 хувь, ямаан сүргийн 47.3 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч малын тоо, / сумаар /

хүснэгт 13

Д/Д	Сум/дүүрэг	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
1	Баянхонгор сум	73472	51	2328	8867	25181	37045
2	Баацагаан сум	154395	987	2936	2349	30985	117138
3	Баянбулаг сум	59842	4	1759	3191	32965	21923
4	Баянговь сум	94769	1677	1367	510	13432	77783
5	Баянлиг сум	107032	8325	1416	615	15357	81319
6	Баян-Овоо сум	118221	85	2902	3150	59657	52427
7	Баян-Өндөр сум	77169	1566	701	230	11664	63008
8	Баянцагаан сум	109750	632	1796	981	26080	80261
9	Богд сум	96850	2137	2037	2380	18067	72229
10	Бөмбөгөр сум	133730	103	3926	2881	38626	88194
11	Бууцагаан сум	129260	792	3805	3106	34052	87505
12	Галуут сум	123646	23	6177	13555	56476	47415
13	Гурванбулаг сум	79417	10	3821	7007	44653	23926
14	Жаргалант сум	72131	3	4235	11441	32532	23920
15	Жинст сум	89561	1001	2161	1029	20981	64389
16	Заг сум	65800	75	3083	3806	30918	27918
17	Өлзийт сум	114347	69	5180	6331	40704	62063
18	Хүрээмарал сум	92634	175	3216	2503	41051	45689
19	Шинэжинст сум	84523	1951	715	137	9959	71761
20	Эрдэнэцогт сум	78552		3919	19136	30005	25492
НИЙТ		1955101	19 666	57 480	93 205	613 345	1 171 405

Хээлтүүлэгчийн тоо / сумаар /

хүснэгт 14

	Бүгд	Буур	Азрага	Бух	Хуц	Ухна
Баянхонгор	1279	1	255	338	296	389
Баацагаан	1976	42	385	89	394	1066
Баянбулаг	972	0	186	124	423	239
Баянговь	1133	64	226	17	261	565
Баянлиг	1500	211	259	27	318	685
Баян-Овоо	993	2	194	91	371	335
Баян-Өндөр	819	47	102	13	179	478
Баянцагаан	1282	23	245	40	320	654
Богд	1354	52	283	87	308	624
Бөмбөгөр	1889	7	463	141	483	795
Бууцагаан	1597	28	460	110	375	624
Галуут	2278	3	553	715	528	479
Гурванбулаг	1338	1	398	198	454	287
Жаргалант	1375	1	423	390	342	219
Жинст	1105	37	245	39	278	506
Заг	1140	5	355	122	329	329
0						
7Өлзийт	1756	2	521	189	466	578
Хүрээмарал	1385	9	303	82	604	387
Шинэжинст	786	68	114	10	156	438
Эрдэнэцогт	1782	0	473	698	333	278
ДҮН	27739	603	6443	3520	7218	9955

Мал аж ахуйн эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 35.0—45.0 хувь, бог малын хувьд сүргийн 50.0—55.0 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг боловч манай аймгийн хувьд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж хээлтэгч малын эзлэх хувь бод малд дундажаар 4.0 хувь, бог малд 41.9 хувь байна.

Ердийн хээлтүүлгийн үед бод малын хувьд 1 хээлтүүлэгчид 10-25 хээлтэгч, бог малын хувьд 1 хээлтүүлэгчид 25 - 30 хээлтэгч ноогдож байвал зохистой харьцаа гэж үздэг. Дээрх хүснэгтээс харахад аймгийн дүнгээр үржлийн 1 бууранд 32 ингэ, үржлийн 1 буханд 26 үнээ, үржлийн 1 хуцанд 84 эм хонь, үржлийн 1 ухнанд 117 эм ямаа ноогдож байгаа нь зохистой түвшний жишигийг хангахгүй байна гэж үзэж болно.

3.2.5 Төл бойжилт

Бойжуулсан төл /тол/

хүснэгт 15

						2018/2017	
						%	зөрүү
Ботго	6838	6532	7367	8666	8477	97.81906	-189
Унага	24532	28220	27107	38146	24974	65.46951	-13172
Тугал	46387	51490	52507	64314	55291	85.9704	-9023
Хурга	317111	366703	378800	469978	287375	61.14648	-182603
Ишиг	644905	728954	712589	907505	368597	40.61653	-538908
Бүгд	1039773	1181899	1178460	1488609	744714	50.0275	-743895

2018 оны байдлаар оны эхний эх малын 46.9 хувь буюу 816618 толгой эх мал төллөж, гарсан төлийн 91.2 хувь буюу 744714 толгой төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос -743895 толгой буюу 50.02 хувиар буурсан байна.

Гарсан ботгоны 97.1 хувь, унаганы 90.3 хувь, тугалны 94.1 хувь, хурганы 93.2 хувь, ишигний 89.1 хувийг бойжуулжээ.

Өмнөх оны бойжуулсан төлтэй харьцуулахад ботго -189, унага -13172, тугал -9023, хурга -182603, ишиг -538908 толгойгоор тус тус буурсан байна.

Хүснэгт 16

Д/д	Сумын нэр	Оны эхний хээлтэгч	Оны эхний хээлтэгчид эзлэх хувь	Төллөсөн хээлтэгч					
				үүнээс					ямаа
				ингэ	гүү	үнээ	хонь		
1	Баянхонгор	66740	68.7	45848	33	1459	6785	15971	21600
2	Баацагаан	140705	16.0	22491	425	861	889	4181	16135
3	Баянбулаг	50737	98.0	49740	1	1333	2797	27854	17755
4	Баянговь	86389	31.1	26860	601	469	286	5562	19942
5	Баянлиг	96519	19.9	19212	3880	340	253	4354	10385
6	Баян-Овоо	104198	18.0	18806	58	836	824	10218	6870
7	Баян-Өндөр	70047	44.1	30907	742	382	128	6831	22824

8	Баянцагаан	103554	59.6	61702	290	1021	469	17607	42315
9	Богд	92563	40.7	37642	841	1182	1612	8751	25256
10	Бөмбөгөр	107190	29.8	31903	36	1099	972	11102	18694
11	Бууцагаан	118610	37.4	44326	357	1740	1619	11216	29394
12	Галуут	105129	67.8	71241	9	3050	7966	33467	26749
13	Гурванбулаг	60076	99.5	59784	6	2583	5387	33587	18221
14	Жаргалант	62284	89.8	55925	1	3061	9239	25628	17996
15	Жинст	86121	24.5	21105	429	562	452	6196	13466
16	Заг	60730	79.3	48186	26	2082	2892	24018	19168
17	Өлзийт	109152	29.4	32116	16	1051	2474	12486	16089
18	Хүрээмарал	75860	57.9	43957	79	2002	1529	20937	19410
19	Шинэжинст	74754	51.0	38138	896	314	66	4750	32112
20	Эрдэнэцогт	69369	81.8	56729	0	2207	12121	23206	19195
	ДҮН	1740727	46.9	816618	8726	27634	58760	307922	413576

хүснэгт 17

Гарсан төл						
	үүнээс					
	ботго	унага	тугал	хурга	ишиг	
45848	33	1459	6785	15971	21600	
22491	425	861	889	4181	16135	
49750	1	1333	2797	27863	17756	
26865	601	469	286	5567	19942	
19216	3880	340	253	4357	10386	
18809	58	836	824	10218	6873	
30914	742	382	128	6838	22824	
61702	290	1021	469	17607	42315	
37642	841	1182	1612	8751	25256	
31903	36	1099	972	11102	18694	
44447	357	1740	1619	11310	29421	
71246	9	3050	7966	33472	26749	
59800	6	2583	5387	33593	18231	
55939	1	3061	9239	25635	18003	
21105	429	562	452	6196	13466	
48186	26	2082	2892	24018	19168	
32129	16	1051	2474	12491	16097	
43957	79	2002	1529	20937	19410	
38157	896	314	66	4759	32122	
56729	0	2207	12121	23206	19195	
816835	8726	27634	58760	308072	413643	

хүснэгт 18

	Хорогдсон төл					
	үүнээс					
	ботго	унага	тугал	хурга	ишиг	
Баянхонгор	7820	0	271	820	2721	4008
Баацагаан	1850	19	109	146	363	1213
Баянбулаг	3091	0	197	253	1302	1339
Баянговь	2739	20	75	7	355	2282
Баянлиг	326	7	47	18	13	241
Баян-Овоо	2839	0	130	179	1338	1192
Баян-Өндөр	2061	79	81	35	472	1394
Баянцагаан	7057	22	45	40	588	6362
Богд	7341	0	126	250	580	6385
Бөмбөгөр	4052	13	153	72	1123	2691
Бууцагаан	3979	23	221	155	734	2846
Галуут	2610	0	123	242	1100	1145
Гурванбулаг	2360	1	179	42	973	1165
Жаргалант	2612	0	280	343	1011	978
Жинст	2620	9	19	47	866	1679
Заг	1928	0	133	127	586	1082
Өлзийт	4671	1	76	131	1053	3410
Хүрээмарал	7558	4	296	289	3745	3224
Шинэжинст	694	51	23	0	98	522
Эрдэнэцогт	3913	0	76	273	1676	1888
ДҮН	72121	249	2660	3469	20697	45046

хүснэгт 19

	Бойжсон төл				
	үүнээс				
	ботго	унага	тугал	хурга	ишиг
38028	33	1188	5965	13250	17592
20641	406	752	743	3818	14922
46659	1	1136	2544	26561	16417
24126	581	394	279	5212	17660
18890	3873	293	235	4344	10145
15970	58	706	645	8880	5681
28853	663	301	93	6366	21430
54645	268	976	429	17019	35953
30301	841	1056	1362	8171	18871
27851	23	946	900	9979	16003
40468	334	1519	1464	10576	26575
68636	9	2927	7724	32372	25604
57440	5	2404	5345	32620	17066
53327	1	2781	8896	24624	17025
18485	420	543	405	5330	11787
46258	26	1949	2765	23432	18086
27458	15	975	2343	11438	12687
36399	75	1706	1240	17192	16186
37463	845	291	66	4661	31600
52816	0	2131	11848	21530	17307
744714	8477	24974	55291	287375	368597

100 эхээс бойжуулсан төл

хүснэгт 20

	2014	2015	2016	2017	2018
Ботго	53	47	48	51	45
Унага	80	78	65	79	46
Тугал	84	82	75	81	62
Хурга	90	88	83	88	49
Ишиг	86	83	75	85	34
Бүгд	86	84	77	85	41

3.2.6 Том малын зүй бус хорогдол

Оны эхний нийт малын 7.9 хувьтай тэнцэх 338390 толгой мал хорогдсон нь өмнөх онтой харьцуулахад толгойгоор 315994 өссөн байна

Хүснэгт 21

Сум	2017 оны Хорогдол бүгд	2018 оны Хорогдол бүгд	Үүнээс					Оны эхний малд эзлэх %	
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа		
1	Баянхонгор	2674	7600	0	343	1069	2453	3735	4.7
2	Баацагаан	262	36463	27	645	1044	5513	29234	11.3
3	Баянбулаг	598	1814	0	59	111	610	1034	1.3
4	Баянговь	1978	21718	85	269	59	1661	19644	10.5
5	Баянлиг	54	16344	157	160	111	1862	14054	7.4
6	Баян-Овоо	1984	41150	0	774	859	9122	30395	18.0
7	Баян-Өндөр	472	9745	38	107	29	1268	8303	5.7
8	Баянцагаан	120	26118	27	44	73	8054	17920	10.6
9	Богд	1608	13628	35	133	363	1062	12035	6.5
10	Бөмбөгөр	3	23382	1	698	1063	7820	13800	8.6
11	Бууцагаан	547	44015	39	772	1069	11117	31018	15.8
12	Галуут	1355	6757	0	618	1089	2504	2546	2.3
13	Гурванбулаг	548	812	0	98	55	382	277	0.4
14	Жаргалант	876	1119	0	157	225	351	386	0.7
15	Жинст	311	25234	43	289	331	4206	20365	13.8
16	Заг	193	1743	0	93	178	561	911	1.1
17	Өлзийт	4282	26896	2	1034	1748	6916	17196	11.4
18	Хүрээмарал	0	22722	4	290	427	10384	11617	11.2
19	Шинэжинст	360	5665	32	54	9	649	4921	3.1
20	Эрдэнэцогт	4177	5471	0	552	1135	1890	1894	2.9
Дун		22402	338396	490	7189	11047	78385	241285	7.9

Нийт хорогдсон малын 71.3 хувийг ямаа, 23.1 хувийг хонь, 3.26 хувийг үхэр, 2.12 хувийг адуу, 0.14 хувийг тэмээ эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол


Хүснэгт 22

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	<u>2017/2018</u>
Тэмээ	177	144	147	55	490	8.9
Адуу	868	1186	2130	922	7189	7.8
Үхэр	1746	2338	8625	2342	11047	4.7
Хонь	14028	11125	33501	6445	78385	12.2
Ямаа	28927	48425	76105	12638	241285	19.1
Бүгд	45746	63218	120508	22402	338396	15.1

Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

Хүснэгт 23

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Тэмээ	0.5	0.4	0.1	0.1	0.8
Адуу	0.9	1.1	0.7	0.6	4.1
Үхэр	1.4	1.6	1.2	1.1	4.6
Хонь	1.8	1.3	0.8	0.5	6.1
Ямаа	1.8	1.5	0.5	0.5	9.7
Бүгд	1.8	1.8	0.6	0.5	7.9



3.2.7 Малын хэрэглээний зарлага

2018 онд оны эхний нийт малын 18.4 хувьтай тэнцэх 783271 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос 203704 толгой малаар буурчээ.

Малын хэрэглээний зарлага /сумаар/

хүснэгт 24

Сум	2016	2017	2018	Үүнээс:				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Баянхонгор	20822	39000	32589	31	1087	5074	12256	14141
Баацагаан	39892	111243	38435	391	1340	1947	12219	22538
Баянбулаг	16915	22922	31124	1	473	1524	18441	10685
Баянговь	19940	40197	31909	320	892	462	6731	23504
Баянлиг	22895	50232	30606	2025	583	257.0	7022.0	20719.0
Баян-Овоо	37348	81995	24635	53.0	960.0	1042.0	13294.0	9286.0
Баян-Өндөр	8988	28295	47626	362.0	430.0	126.0	8308.0	38400.0
Баянцагаан	23824	53135	58470	231	1131	583	16779	39746
Богд	29929	62435	33502	814	1547	1530	9726	19885
Бөмбөгөр	23652	51665	30156	24	940	632	7688	20872
Бууцагаан	25494	68182	34617	192	1435	1370	11030	20590
Галуут	34583	52671	67930	12	2749	5898	34777	24494
Гурванбулаг	16557	29158	38466	8	1442	3778	20897	12341
Жаргалант	22293	33595	48832	1	1956	7001	24753	15121
Жинст	24433	52209	36076	307	1217	568	10283	23701
Заг	18055	37351	39750	26	1457	2476	20733	15058
Өлзийт	36257	64930	40033	18	2232	2996	15034	19753
Хүрээмарал	19005	37432	31983	17	1251	1476	16928	12311
Шинэжинст	14639	33546	39476	373	476	58	5520	33049
Эрдэнэцогт	23647	36782	47056		1745	10238	20449	14624
Дүн	479168	986975	783271	5206	25343	49036	292868	410818

Оны эхний нийт малаас тэмээний 9.6 хувь, адууны 14.1 хувь, үхрийн 20.4 хувь, хонины 21.2 хувь, ямааны 15 хувийг малын хэрэглээнд зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 10.2 хувийг бод мал, 89.8 хувийг бог мал эзэлж байна.

3.3.2 Шинээр гаргасан худгийн тайлан

Монгол улсын Засгийн газраас хүн ам, малын усны хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалтыг сайжруулахад анхаарал хандуулж, худаг уст цэгийг шинээр гаргах, сэргээн засварлахад зориулан тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байна.

Энэ онд 41 худаг шинээр ашиглалтанд орсноос 65.8 хувь буюу 27 нь инженерийн хийцтэй, 34.1 хувь буюу 14 нь энгийн уурхайн худаг байна.

Шинээр гаргасан худгийн тоо /сумаар/

Хүснэгт 25

Сумын нэр	Үүнээс				
			Үүнээс		
Баацагаан сум	4	2	1	1	2
Баянговь сум	4	1	1		3
Баянлиг сум	9	6	6		3
Баян-Овоо сум	2	2	2		
Баян-Өндөр сум	1	1	1		
Богд сум	3	3	3		
Бууцагаан сум	12	9	9		3
Өлзийт сум	2	2	2		
Шинэжинст сум	3				3
Эрдэнэцогт сум	1	1	1		
Дүн	41	27	26	1	14

* Худаг, усалтын системийг анх барьж байгуулахад гүйцэтгэсэн үйл ажиллагаагаар нь инженерийн хийцтэй болон энгийн уурхайн гэж ялгагдаг.

Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгө /сумаар/

хүснэгт 26

Сумын нэр	Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мян.төг/	Үүнээс:			Худаг шинээр гаргахад түр ажилласан орон нутгийн иргэдийн тоо
Баацагаан сум	49500.0		47000.0	2500.0	19
Баянговь сум	31500.0		25000.0	6500.0	16
Баянлиг сум	46500.0	14000.0		32500.0	97
Баян-Овоо сум	30000.0	10000.0	20000.0		10
Баян-Өндөр сум	16000.0	16000.0			2
Богд сум	60000.0	27000.0	29000.0	4000.0	3
Бууцагаан сум	52800.0			52800.0	23
Өлзийт сум	30000.0		30000.0		
Шинэжинст сум	17700.0	16000.0		1700.0	5
Эрдэнэцогт сум	18900.0	17800.0		1100.0	
Шинэжинст сум	352900.0	100800.0	151000.0	101100.0	175

* Худаг, услалтын системийг анх барьж байгуулахад гүйцэтгэсэн үйл ажиллагаагаар нь инженерийн хийцтэй болон энгийн уурхайн гэж ялгагдаг.

2018 онд шинээр худаг гаргахад нийт 352900.0 мян.төгрөг зарцуулсны 28.6 хувь нь улсын төсвийн хөрөнгөөр, 42.8 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр, 28.6 хувийг малчид, иргэдийн өөрийн хөрөнгө буюу бусад эх үүсвэрээр санхүүжигдсэн байна.

2018 онд Малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлан

2018 оны байдлаар Аймгийн 271 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан байна. Тус 271 өрхөд 11783 толгой мал олгогдсон бөгөөд нийт малын 0.9 хувь нь бод мал, 99.1 хувь нь бог мал байна. Нэг өрхөд дунджаар 43.5 толгой мал ногдож байна.

Малжуулах арга хэмжээнд нийт 581415.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд үүний 27.3 хувь нь гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр, 40.6 хувь нь орон нутгийн хөрөнгөөр, 32.1 хувь нь бусад эх үүсвэрээс санхүүжигдсэн байна

Малжуулалтын талаар авсан арга хэмжээний тайлан

Хүснэгт 27

Сумын нэр	Үүнээс			
	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бүгд /мян.төг/	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр /мян.төг/	Орон нутгийн хөрөнгөөр /мян.төг	Бусад /мян.төг/
Баацагаан сум	39500.0	13500.0	26000.0	
Баянговь сум	43375.0		15000.0	28375.0
Баянлиг сум	27060.0		15000.0	12060.0
Баян-Овоо сум	31500.0	31500.0		
Баян-Өндөр сум	22500.0		22500.0	
Баянцагаан сум	20500.0		14000.0	6500.0
Богд сум	38550.0	28050.0		10500.0
Бууцагаан сум	102340.0	55000.0	15000.0	32340.0
Гурванбулаг сум	24750.0		8250.0	16500.0
Өлзийт сум	60140.0	4400.0	22500.0	33240.0
Хүрээмарал сум	92200.0		78200.0	14000.0
Шинэжинст сум	31000.0		19500.0	11500.0
Эрдэнэцогт сум	48000.0	26000.0		22000.0
	581415.0	158450.0	235950.0	187015.0

Хүснэгт

28

Сумын нэр	Малжуулалтаар авсан малын тоо	Үүнээс		Малжуулалтанд хамрагдсан	
		Бодын тоо	Богийн тоо	өрхийн тоо	ам бүлийн тоо
Баацагаан сум	780		780	14	56
Баянговь сум	830		830	17	76
Баянлиг сум	474	4	470	18	62
Баян-Овоо сум	569	10	559	9	28
Баян-Өндөр сум	500		500	6	21
Баянцагаан сум	634	1	633	17	65
Богд сум	810		810	20	86
Бууцагаан сум	2565	5	2560	77	321
Гурванбулаг сум	450		450	9	26
Өлзийт сум	948	70	878	17	54
Хүрээмарал сум	1508		1508	21	83
Шинэжинст сум	650		650	13	54
Эрдэнэцогт сум	1065	14	1051	33	132
	11783	104	11679	271	1064

III.4 ГАЗАР ТАРИАЛАН

Тариалсан талбай

Аймгийн хэмжээнд 2018 онд үр тариа 3.2 га-д, төмс 197.5 га-д, хүнсний ногоо 115.1 га-д. 227.5 га-д тэжээлийн ургамал тус тус тариалалт хийсэн нь, өмнөх онтой харьцуулахад үр тариа 4.4 хувь буюу 0.4 га-аар, төмс 6.3 хувь буюу 15 га-аар тус тус өсч, хүнсний ногоо 11.7 хувь буюу 19.2 га-аар буурсан байна.

хүснэгт 29

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/ 2017
Бүгд талбай:	402.1	424.4	411.2	407.4	315.8	77.5
Үүнээс: үр тариа	10.6	12.0	9.1	9.5	3.2	33.7
төмс	225.3	244.3	238.4	253.4	197.5	77.9
хүнсний ногоо	166.2	168.1	163.7	144.5	115.1	79.7

Тариалсан талбай /сумаар/

хүснэгт 30

Сум/дүүрэг	Үр тариа	Төмс	Тэжээлийн ургамал	ногоон тэжээл	олон наст	Хүнсний ногоо
Баянхонгор сум		91.1	2.5	2.5		35.5
Баацагаан сум						2.0
Баянбулаг сум						
Баянговь сум		4.6	23.3	23.3		2.4
Баянлиг сум	3.2	6.4	10.5	10.5		4.4
Баян-Овоо сум		19.5	33.6	33.6		19.6
Баян-Өндөр сум		0.15	0.2	0.2		0.1
Баянцагаан сум		5.7	49	45	4	5.7
Богд сум						0.0
Бөмбөгөр сум		0.5	5.3	5.1	0.2	0.4
Бууцагаан сум		1	4	4	0	0.6
Галуут сум		2.11	10	10		1.0
Гурванбулаг сум						
Жаргалант сум		3.2	1	1		1.4
Жинст сум		2.7	8		8	2.6
Заг сум		4				1.7
Өлзийт сум		43	25		25	22.0
Хүрээмарал сум		0.2	34		34	0.4
Шинэжинст сум			0.5	0.5		1.8
Эрдэнэцогт сум		13.3	20.6	0.9	19.7	13.5
Бүгд	3.2	197.5	227.5	136.6	90.9	115.1

Хураан авсан ургац

Хураасан ургац /төрөл, тонноор/

Хүснэгт 31

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/ 2017
Бүгд:	4687.8	4940.3	5131.9	2355.3	2899.5	123.1
Үүнээс: Үр тариа	17.9	21.8	14.5	13.1	8.5	64.9
Төмс	2612.2	2781.1	2912.6	1547.9	1907.7	123.2
Хүнсний ногоо	2057.7	2137.4	2204.8	794.3	983.4	123.8

Хураасан ургац /сумаар, тонноор/

Хүснэгт 32

Сумын нэр	БҮГД								
	Үүнээс					Үүнээс			
	арвай	Ногоон тэжээл				Олон наст			
Баянхонгор			838.7	414.5	16	16		217.5	113.9
Баацагаан				1.1				106.0	46.0
Баянбулаг								124.5	137.3
Баянговь			20.0	6.1	40	40		218.3	160.3
Баянлиг	8.5	8.5	48.0	34.3	40	40		225.2	79.5
Баян-Овоо			253.5	138.7	134.4	134.4		11257.0	67.3
Баян-Өндөр			0.5	0.5	0	0		222.3	135.5
Баянцагаан			59.5	8.1	42	42	0	73.0	393.0
Богд				0.1				897.3	184.0
Бөмбөгөр			4.0	3.4	11	10	1	201.7	171.7
Бууцагаан			5.0	3.1	10	10		57.5	49.2
Галуут			2.3	0.4	0	0		53.5	23.1
Гурванбулаг								53.0	85.4
Жаргалант			16.0	3.5	0.5	0.5		238.4	95.8
Жинст			18.0	12.3	0		0	133.0	55.0
Заг			6.0	2.7				86.2	63.6
Өлзийт			516.0	206.0	75		75	205.3	13.9
Хүрээмарал			2.2	3.0	10		10	105.7	341.6
Шинэжинст				27.0	0.4	0.4		75.0	30.0
Эрдэнэцогт			118.0	118.6	41.2	9	32.2	85.8	140.0
Нийт	8.5	8.5	1907.7	983.4	420.5	302.3	118.2	14636.2	2386.0

2018 онд аймгийн дүнгээр 2899.5 тонн төмс, хүнсний ногоо, үр тариа хураан авсны 0.2 хувь нь үр тариа, 65.8 хувь нь төмс, 33.9 хувь нь хүнсний ногоо байна.

Тэжээлийн ургамал 227.5 га-д тариалалт хийж 420.5 тонн ургац хураан авсан

Бэлтгэсэн өвс хадлан / сумаар, тонноор /

Хүснэгт 33

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2018/ 2017
Баянхонгор	50	231	246.8	71	217.5	306.3
Баацагаан	97.1	304.5	846.8	323.5	106.0	32.8
Баянбулаг	55	214.5	300	95.4	124.5	130.5
Баянговь	105	101	76	87	218.3	250.9
Баянлиг	73	79.5	185	186.1	225.2	121.0
Баян-Овоо	63.5	293	1800	11372	11257.0	99.0
Баян-Өндөр	280	40	41.5	63	222.3	352.8
Баянцагаан	295	71.4	185	60	73.0	121.7
Богд	1138.5	1155	1300	1260	897.3	71.2
Бөмбөгөр	52	450	2145	413.85	201.7	48.7
Бууцагаан	260.1	310	500	86	57.5	66.9
Галуут	131	161	186	168.0	53.5	31.9
Гурванбулаг	70	250	176	177	53.0	29.9
Жаргалант	121.5	319.7	350	354	238.4	67.3
Жинст	142.3	196.3	232	174.5	133.0	76.2
Заг	65	87.2	216	98	86.2	88.0
Өлзийт	399.1	431.2	898.3	101.6	205.3	202.1
Хүрээмарал	160	165.5	1800.9	115	105.7	91.9
Шинэжинст	19	156	85	605.5	75.0	12.4
Эрдэнэцогт	331.4	34	78.2	38.25	85.8	224.2
Дүн	3908.5	5050.8	11648.5	15849.7	14636.2	92.3

III.6 БАЯНХОНГОР АЙМГИЙН БҮСЭД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Малтай өрх, мал, малчин өрх, малчдын тоо

хүснэгт 34

	Улсын дүн		Хангайн бүс		Баянхонгор аймаг		Баянхонгор аймгийн бүсэд эзлэх хувь
Малын тоо/мян,тол/	66219	66459.2	24404.8	24323.1	4587.7	4249.5	17.5
Малтай өрхийн тоо	228948	230853	83830	84944	14566	14765	17.4
Малчин өрхийн тоо	169743	169705	69105	69123	11821	11920	17.2
Малчдын тоо	303590	288698	124682	120381	22255	21784	18.1

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр улсын хэмээнд 66.4 сая мал тоологдож манай аймаг нийт малын тооны 6.3 хувь, тэмээн сүргийн 12.4 хувь, адуун сүргийн 4.4 хувь, үхэр сүргийн 5.4 хувь, хонин сүргийн 4.2 хувь, ямаан сүргийн 9.1 хувийг тус тус эзэлж улсад нийт малын тоогоороо байранд зургадугаарт орж, малын төрөлдөө ямаагаараа нэгдүгээр байранд орж, тэмээгээрээ хоёрдугаар байрт орлоо.

Хангайн бүсийн хэмжээнд 24.3 сая мал тоологдсоны 4.2 сая буюу 17.5 хувийг манай аймгийн малын тоо эзэлж байна.

.Малтай өрхийн тоогоор бүсэд 17.4 хувь, малчин өрхийн тоогоор 17.2 хувь, малчдын тоогоор 18.1 хувийг тус тус эзэлж байна.

Малчдын ахуй соёлын үзүүлэлт

хүснэгт 35

	Улсын дүн		Хангайн бүс		Баянхонгор аймаг		Баянхонгор аймгийн бүсэд эзлэх хувь
Цахилгаан үүсгүүртэй өрх	138459	136721	55627	55100	9987	9625	17.5
Телевизортой өрх	120219	119288	48929	48325	8970	8726	18.1
Автомашинтай өрх	71370	79030	24259	26761	4667	5084	19
Мотоцикльтой өрх	76633	83563	32751	34918	7129	7306	20.9

Малчдын ахуй соёлын үзүүлэлт нь малчин өрхийн өсөлт, бууралтаас шалтгаалан өсч, буурч байдаг ба 2018 оны байдлаар цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 9625 болж өмнөх оноос 362 өрхөөр буурсан, бүсийн дүнд харьцуулахад 17.5 хувийг, телевизортой өрхийн тоо 8726 болж өмнөх оноос 244 өрхөөр буурч бүсийн дүнд 18.1 хувийг, автомашинтай өрхийн тоо 5084 болж өмнөх оноос 417 өрхөөр өсч бүсийн дүнд 19 хувийг, мотоцикльтой өрхийн тоо 7306 болж өмнөх оноос 177 өрхөөр өсч бүсийн дүнд 20.9 хувийг тус тус эзэлж байна.

**Хураан авсан ургац /тн/
хүснэгт 36**

	Улсын дүн		Хангайн бүс		Баянхонгор аймаг		Баянхонгор аймгийн бүсэд эзлэх хувь
Үр тариа	238101.9	453849.2	42422.3	105526.2	13.1	8.5	0.01
Төмс	121808.5	168882.6	16882.8	18267	1548	1907.7	10.4
Хүнсний ногоо	82102	100731.7	9055.9	9852.5	794.3	983.4	9.98
Бэлтгэсэн хадлан /мян.тн/	1008.1	1229.4	308.6	433.8	15.8	14.6	3.37

Баянхонгор аймгийн хэмжээнд хураан авсан ургац нь бүсэд үр тариа 8.5 тн буюу 0.01 хувь, төмс 1907.7 тн буюу 10.4 хувь, хүнсний ногоо 983.4 тн буюу 9.98 хувь, бэлтгэсэн хадлан 14.6 мян тн буюу 3.4 хувийг тус тус эзэлж байна.

ДҮГНЭЛТ

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр манай аймгийн малын тоо 4249.5 мянга болж, өмнөх оныхоос 338.2 мянга буюу 7.4 хувиар буурлаа. Малын тоо Баянбулаг, Галуут, Гурванбулаг, Жаргалант сумдад 874 - 21216 толгойгоор өсч, бусад сумд 3785 - 40258 толгойгоор буурчээ. Малын тоо буурах шалтгаан нь нэгдүгээрт: Оны эхний хээлтэгч (1825497)-ийн 44.7 хувь буюу 816618 нь төллөсөн бол гарсан төлийн 91.2 хувь буюу 744714 толгой төл эсэн мэнд бойжсон ба энэ нь сүүлийн 5 жилд тохиолдоогүй цөөхөн төл бойжуулсан жил байлаа. Хоёрдугаарт: Малын үнэ ханш харьцангуй өндөр байсантай холбоотойгоор зах зээлд худалдаж борлуулсан, хүнсэнд хэрэглэсэн малын тоо өссөн (783211), мөн хаваржилт хүндэрч, зуншлага аажуу болсонтой холбоотойгоор том малын зүй бусын хорогдол (338409) өмнөх жилүүдээс өндөр гарсантай шууд холбоотой юм.

2018 онд нийт малтай өрхийн тоо 14.7 мянга байгаа бөгөөд үүний 11.9 мянга нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 21.8 мянган малчид ажиллаж байна.

Нийт малтай өрхөд таван зуугаас дээш малтай өрхийн тоо 2367 болсны дотор 419 айл өрх нь 1000-аас дээш малтай болжээ. Таван зуугаас дээш малтай өрхийн тоо өмнөх оноос 15.4 хувиар буюу 430 өрхөөр буурсан байна.

Мал бүхий иргэд малчид 2018 онд 744.7 мянган төл бойжуулж, бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 743.9 мянган толгойгоор буурсан байна.

Малгүй айлыг малжуулах арга хэмжээний хүрээнд төрөл бүрийн төсөл, орон нутгийн санхүүжилтээр 271 айл өрхийг 11.8 мянган малтай болгоход 581.4 сая төгрөг зарцуулжээ.

2018 онд аймгийн дүнгээр 2899.5 тонн төмс, хүнсний ногоо, үр тариа хураан авсны 0.2 хувь нь үр тариа, 65.8 хувь нь төмс, 33.9 хувь нь хүнсний ногоо байна.

Тэжээлийн ургамал 227.5 га-д тариалалт хийж 420.5 тонн ургац хураан авсан

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд гарч байгаа өсөлт нь малын тооноос хамаарч байгаа бөгөөд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх ажил шаардлагатай байна.

Мөн ямаан сүргийн тоог сүүлийн 18 жилээр авч үзвэл 15 жилд нь өсч, 3 жилд нь буурсан байгаагаас харахад бог малын хувьд уламжлалт сүргийн бүтцийн харьцаа 75:25 хувь буюу 3 хонь 1 ямаа гэсэн харьцаагаар өсгөж үржүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

Ямаанаас гарах ноолуурын ашиг шимийг хүртэх нь ноолуур үнэтэй энэ цаг үед малчдын амьжиргаанд ихээхэн нэмэртэй ба ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаан сүргээ түлхүү өсгөх хандлага байна.

Манай аймгийн хувьд бог малын харьцаа 66.4 : 33.6 хувь буюу ямааны тоо толгой нийт сүргийн 59.9 хувь ба бог малд эзлэх хувь 66.4 хувь болж цаашид өсөх хандлагатай байна.

Баянхонгор аймаг нь манай улсын хамгийн олон малтай 5 аймгийн нэг бөгөөд улсад ямааны тоогоороо тэргүүлж, тэмээний тоогоор хоёрт ордог. Манай аймагт Баян-Өндөр сумын бие том, ноос ихтэй тэмээ, Байдраг үүлдрийн хонь, Залаа жинстийн ноолуурийн цагаан ямаа зэрэг өндөр ашиг шимтэй нутгийн шилдэг омог хэвшлийн мал сүргийг өсгөн үржүүлдэг.

Нутгийн шилдэг омог, үүлдрийн малыг өсгөн үржүүлж, хүрээг нь өргөжүүлэх, малын омог, үүлдэрлэг байдлыг сайжруулах замаар ашиг шимийг нь дээшлүүлэх явдал аймаг, сум, багийн түвшинд бодлого боловсруулагчдын өмнө эрхэм чухал зорилт болон дэвшигдэж байна.

Судалгааны хамрах хугацаа

2011-2018 он

Мэдээллийн эх үүсвэр

- Баянхонгор аймгийн 2010-2018 оны жилийн эцсийн мал тооллогын материал
- , 2010, 2011, 2012, 2013, 2014, 2015 2017 2018 оны улсын статистикийн эмхэтгэл
- ҮСХ-ны жилийн эцсийн бюллетень танилцуулга
- www.1212.mn

